



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 484

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хүүхдийн төв номын сангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид сэлбэн засаж ашиглах боломжгүй, сургалтын агуулгад нийцэхгүй болсон нийт 7,392,181.00 (долоон сая гурван зуун ерэн хоёр мянга нэг зуун наян нэгэн) төгрөгийн балансын үнэ бүхий 2513 ширхэг номыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Хүүхдийн төв номын сангийн захирал Д.Оюунбилэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, ашиглаж болох номыг үнэ хямдруулан худалдах буюу хоёрдогч түүхий эд хүлээн авах байгууллагад зохих үнээр нь худалдах, түүх, соёлын хэрэгцээ шаардлагыг харгалзан 1-3 ширхэгийг үлдээх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогыг (худалдахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр) улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

